



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 2 дугаар сарын 4-ний
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 16

ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд даалгасугай.

3. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг эрхэлсэн салбар болон тухайн орон нутагтаа хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах арга хэмжээнд зарцуулах нэмэлт хөрөнгийг бүрдүүлэх чиглэлээр тодорхой санаачилга гарган ажиллахыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2012 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Хүн амын хөгжил, нийгмийн

хамгааллын сайд

С.ЭРДЭНЭ

ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын макро эдийн засгийн байдал тогтворгүй байгаа хэдий ч хүн амын амьжиргааны түвшинд эерэг өөрчлөлт ажиглагдаж байна. Ядуурлын түвшин 2011 онд 33,7 хувь байсан бол 2014 онд 21,6 хувь болж, 12,1 пунктээр буурчээ. Түүнчлэн Монгол Улсын хүний хөгжлийн индекс 2014 онд 0,748 болж өмнөх үеийнхээс даруй 0,009 пунктээр, 2011 оныхоос 0,025 пунктээр нэмэгдсэн байна. Үүнээс орлогын индекс 0,042, боловсролынх 0,016, дундаж наслалтын индекс 0,020 пунктээр тус тус өсчээ .

Монгол Улсын Засгийн газраас 2012-2015 онд “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлсэн билээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд нийгмийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай өрх, иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг багцлан хүргэж, тэдний сөрөг дадал, хэвшлийг нь нийгмийн ажилтны оролцоо, дэмжлэгтэйгээр өөрчлөхөд чиглэсэн “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г 55 мянга гаруй өрх бүрт боловсруулан хэрэгжүүлж, хөтөлбөрт хамрагдсан 17 мянган өрхийн амьжиргаанд эерэг өөрчлөлт гарсан байна .

Түүнчлэн НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-т 2030 он гэхэд дэлхий нийтээрээ ядуурлаас ангижирсан байх зорилтыг дэвшүүлснээр улс орон бүр ядуурлыг бууруулах, өрх иргэдийнхээ аж байдлыг сайжруулах замаар улс орныхоо хөгжлийн түвшинг нэмэгдүүлэх зорилго, зорилт тавьж байна.

Иймд Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлэх”-ээр тусгасан зорилт, Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулан амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэх зорилгоор “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр” (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг боловсрууллаа.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг тодорхойлж, тэдгээр өрх, өрхийн гишүүдийн эрэлт, хэрэгцээ, санаачилга, боломжид тулгуурлан боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн зэрэг үйлчилгээг багцлан хүргэх замаар зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулан амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэхэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтын дэвшүүлнэ:

3.1.1. өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх замаар амьжиргааны түвшинг дээшлүүлэх;

3.1.2. нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг зорилтот өрхийн гишүүн бүрт оновчтой хүргэх;

3.1.3. өрхийн гишүүдийн сөрөг зан үйл, дадал хэвшлийг өөрчилж, гэр бүлийн эерэг, таатай харилцааг төлөвшүүлэх;

3.1.4. зорилтот өрхийн хөгжил, амьжиргааны талаарх цахим мэдээллийн санг байгуулж, түүний хэрэглээг нэмэгдүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

4.1.1. өрхийн хэрэгцээ, гишүүдийн оролцоо, санаачилга, чадвар, боломжийг харгалзах;

4.1.2. орон нутаг, олон нийт, бүх салбарын оролцоонд тулгуурлах;

4.1.3. хөтөлбөрийн үйл ажиллагаанд өрх, түүний гишүүд сайн дурын үндсэн дээр хамрагдах;

4.1.4. үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

4.1.5. өрхөд хүргэх нийгмийн үйлчилгээ нь иж бүрэн багцлагдсан байх.

Тав. Хөтөлбөрт хамруулах өрх, түүнд тавигдах шаардлага, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга

5.1. Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн бага болон дунд хэрэглээтэй, дараах шаардлагыг хангасан өрх (цаашид “зорилтот өрх” гэх)-ийг хөтөлбөрт хамруулна:

5.1.1. орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдсан;

5.1.2. өрхийн нөхцөл байдлын үнэлгээ хийлгэж, хөгжлийн бүлгээ тодорхойлуулсан.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө” байна. Өрхийн хөгжлийн төлөвлөгөө нь өрхийн нөхцөл байдал, хэрэгцээ, нөөц боломж, чадавхид тулгуурлан өрхийг хөгжүүлэх, амьжиргааг сайжруулах зорилготой, тусгайлсан арга зүй бүхий цогц үйл ажиллагаа байна.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гүйцэтгэх чиг үүрэг

6.1. Сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.1.1. сум, хорооны хэмжээнд хөтөлбөрт хамруулахаар сонгосон зорилтот өрхийн нөхцөл, байдлын үнэлгээ хийх, үнэлгээний дүнг нэгтгэх, эрэмбэлэх, дүн шинжилгээ хийх;

6.1.2. зорилтот өрхийн гишүүдийн хэрэгцээ, ур чадвараар нь ангилсан судалгааг гаргаж, Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах санал боловсруулах, уламжлах;

6.1.3. өрх бүрийн амьжиргааг дээшлүүлэх хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6.1.4. зорилтот өрхийн амьжиргаанд гарч байгаа өөрчлөлтийг хянах, мэдээлэх;

6.1.5. зорилтот өрхийн гишүүдийг нийгмийн үйлчилгээнд хамрагдахад шаардагдах бичиг баримттай холбоотой асуудлыг шийдвэрлэх талаар зөвлөгөө өгөх, шаардлагатай туслалцаа үзүүлэх;

6.1.6. зорилтот өрхийн гишүүн болон тухайн өрхийн бусад гишүүдийн хүсэлтийг үндэслэн өрхийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнийг шаардлагатай асрамжийн үйлчилгээнд хамруулж, бусад гишүүдийг ажил эрхлэх, олон нийтийн арга хэмжээнд оролцоход дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

6.1.7. зорилтот хөдөлмөрийн насны гишүүдийг хуульд заасны дагуу нийгмийн даатгалд заавал болон сайн дураар даатгуулах талаар зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлэх.

6.2. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.2.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтарсан багийг мэргэжлийн удирдлагаар хангах;

6.2.2. аймаг, дүүргийн хэмжээний зорилтот өрхийн амьжиргааг дээшлүүлэх хөгжлийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

6.2.3. хөтөлбөрийн 6.1.2-т заасан судалгааны дагуу зорилтот өрхийн гишүүдийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах санал боловсруулах, уламжлах;

6.2.4. зорилтот өрх, өрхийн гишүүдийг хууль тогтоомжид заасан нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах шийдвэр гаргах;

6.2.5. хөтөлбөрийн үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээтэй уялдуулан хэрэгжүүлэх;

6.2.6. хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

6.2.7. хөтөлбөрт хамрагдсан өрх, иргэдэд хүргэж байгаа үйлчилгээ, гарсан үр дүнгийн талаар цахим мэдээллийн сан байгуулах.

6.3. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.3.1. хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны жил бүрийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангуулах;

6.3.2. хөтөлбөрийн үйл ажиллагааг төсвийн тухай хууль тогтоомж, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулах;

6.3.3. хөтөлбөрийн үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийг Засгийн газрын 2013 оны 97 дугаар тогтоолоор байгуулагдсан Хүн амын асуудлаарх үндэсний хороонд танилцуулах;

6.3.4. хөтөлбөрийн үйл ажиллагааг олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөртэй уялдуулах, холбогдох бусад байгууллагыг оролцуулах ажлыг зохион байгуулах;

6.3.5. аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээнд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусган хяналт тавьж ажиллах;

6.3.6. өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал, өрхийн хөгжлийн төлөвлөгөөний загварыг шинэчлэн батлах;

6.3.7. хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөтөлбөрт өөрчлөлт оруулах санал боловсруулах.

6.4. Бүх шатны Засаг дарга хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.4.1. хөтөлбөрийн үйл ажиллагааг өөрийн үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилт, орон нутгийн холбогдох байгууллагын төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлэх;

6.4.2. сум, дүүргийн энэ хөтөлбөрийн 5.1-д заасан шаардлагыг хангасан өрхийг сонгон жил бүрийн 6 дугаар сарын 20-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулах;

6.4.3. зорилтот өрхийн нөхцөл байдлыг үнэлэн өрхийн гишүүдийн хэрэгцээ, чадавх, боломжийг нь тодорхойлж, зорилтот өрх бүрт амьжиргааг нь дээшлүүлэх хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор багтаан зохион байгуулах;

6.4.4. хөтөлбөрийн үйл ажиллагааг орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд тусган иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

6.4.5. зорилтот өрхөд мэдээлэл өгөх, хамтран бүлэг байгуулах болон харилцан туршлага солилцох, бага хэмжээний хөрөнгөөр эрхэлж болох бизнесийн санааг танилцуулах уулзалт, семинар зохион байгуулах;

6.4.6. зорилтот өрхийн гишүүдийг чадавхижуулах, эерэг дадал, хэвшил төлөвшүүлэх, өрхийн гишүүдийн нийгэм, гэр бүл, хөршийн харилцаагаа сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа, сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө өгөх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

6.4.7. зорилтот өрхийг хөгжүүлэх, хамгаалахад чиглэсэн сайн дурын аян, үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгыг дэмжин урамшуулах.

6.5. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.5.1. зорилтот өрхийн гишүүдийг хөдөлмөр эрхлүүлэх замаар байнгын орлогын эх үүсвэртэй болгоход чиглэсэн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, холбогдох хөтөлбөр, журам боловсруулан хэрэгжүүлэх, шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгах зэрэг арга хэмжээг хариуцан хэрэгжүүлнэ.

6.6. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.6.1. энэ хөтөлбөрийн 6.1.2-т заасан судалгаанд үндэслэн жил бүрийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөв, төлөвлөгөөнд зорилтот өрхийн гишүүдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд эхний ээлжинд хамруулах асуудлыг тусгах, хэрэгжүүлэх;

6.6.2. хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах зорилтот өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийг өөрсдийнх нь хүсэлт, Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дагуу нийтлэг үйлчилгээнд хамруулах;

6.6.3. зорилтот өрхийн гишүүн энэ хөтөлбөрийн 6.6.2-т заасан нийтлэг үйлчилгээнд хамрагдсан боловч ажилд орж чадаагүй, эсхүл ажилд олоход хүндрэлтэй иргэн байвал хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулж, холбогдох зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх;

6.6.4. зорилтот өрхийн хөдөлмөрийн насны гишүүн хувиараа хөдөлмөр эрхлэх буюу эрхэлж байгаа аж ахуй, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой бол Өрхийн хөгжлийн төлөвлөгөө, уг иргэний аж ахуй эрхлэх ур чадвар, дадлага, туршлагыг харгалзан хуульд заасан дэмжлэг үзүүлэх.

6.7. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.7.1. зорилтот өрхийн гишүүдийг холбогдох боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулахад шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх, холбогдох хөтөлбөр, журам боловсруулан хэрэгжүүлнэ.

6.8. Аймаг, нийслэл, дүүргийн боловсролын байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.8.1. хөтөлбөрийн 6.1.2-т заасан судалгааны дагуу сургуулийн өмнөх насны бүх хүүхдийг нь цэцэрлэгт бүрэн хамруулах, зорилтот өрхийн хүүхдийг цэцэрлэгт авах талаар хувийн өмчийн цэцэрлэгээс гаргасан санаачилгыг дэмжин урамшуулах;

6.8.2. зорилтот өрхийн суурь боловсрол эзэмших насны хүүхдийг сургуульд хамрагдах, суралцах боломжийг бүрдүүлж, сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, сурагчийн дүрэмт хувцас зэргийн үнийг хөнгөлөх, чөлөөлөх, дотуур байраар хангах;

6.8.3. зорилтот өрхийн сургууль завсардсан хүүхдийг албан бус сургалтад хамруулж, дүйцүүлэх хөтөлбөрөөр зохих шатны боловсрол эзэмшүүлэх, уг сургалтад хамрагдаж байгаа хүүхдэд энэ хөтөлбөрийн 6.8.2-т заасан хөнгөлөлт үйлчилгээг үзүүлэх;

6.8.4. суурь боловсрол эзэмшсэн хүүхэд болон үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй насанд хүрсэн гишүүнийг Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллежид суралцахад дэмжлэг үзүүлэх;

6.8.5. ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги төгсөж, зохих журмын дагуу их, дээд сургууль, коллежид суралцах эрх авсан хүүхэд, өрхийн гишүүнийг сургалтын тэтгэлэг, буцалтгүй тусламж, зээлд хамруулахад дэмжлэг үзүүлэх.

6.9. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.9.1. зорилтот өрхийн гишүүдэд эрүүл мэндийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх, холбогдох хөтөлбөр, журам боловсруулан хэрэгжүүлэх.

6.10. Аймаг, нийслэлийн эрүүл байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

- 6.10.1. зорилтот өрхийн гишүүн бүрийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу эрүүл мэндийн даатгалд хамруулах;
- 6.10.2. зорилтот өрхийн гишүүдийг нийгмийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, сургалтад хамруулах, шаардлагатай бол төрөх насны эмэгтэйчүүдийг жирэмслэлтээс хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг хянах;
- 6.10.3. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шаардлагатай жирэмсэн эх, нярай хүүхэд, ахмад настан, хүнд өвчтэй болон хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд холбогдох тусламж, үйлчилгээг хүргэх ажлыг тусгайлан зохион байгуулах;
- 6.10.4. зорилтот өрхийн гишүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг явуулын болон бусад хэлбэрээр зохион байгуулах;
- 6.10.5. зорилтот өрхийн хүүхдийг заавал хийх дархлаажуулалтад бүрэн хамруулах.
- 6.11. Аж ахуйн нэгж, байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:
- 6.11.1. зорилтот өрхийн гишүүдийг мэргэшүүлэх болон ажиллуулж болох ажлын байрны жагсаалтыг гарган, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад мэдээлэх, ажлын байраар хангах;
- 6.11.2. ажиллагчдынхаа амьжиргааг дээшлүүлэх талаар санал, санаачилга гаргах;
- 6.11.3. шинээр бий болгосон ажлын байр, нийтийг хамарсан ажил, зарцуулсан хөрөнгө зэрэг мэдээллийг нээлттэй байлгах, үйл ажиллагаагаа сурталчлах;
- 6.11.4. хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нутгийн захиргааны байгууллагад хөрөнгө санхүү, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх.
- 6.12. Төрийн бус байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:
- 6.12.1. зорилтот өрхөд Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг гэрээгээр гүйцэтгэх;
- 6.12.2. хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийхэд оролцох.
- 6.13. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.5-д заасан иргэн, аж ахуйн нэгж хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар дараах үүргийг гүйцэтгэнэ:
- 6.13.1. өрх, иргэнтэй ажиллах чиглэлээр нийгмийн ажилтны чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх сургалтыг холбогдох байгууллагын захиалгаар зохион байгуулах;
- 6.13.2. ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, бизнес эрхлэх, гэр бүлийн боловсрол олгох, сөрөг дадал, хэвшлийг өөрчлөх чиглэлээр хөтөлбөрт хамрагдсан өрхийн гишүүдэд зориулсан сургалт, дадлага зохион байгуулах;
- 6.13.3. хөтөлбөрт хамрагдсан иргэдэд мэргэжил олгох, ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын хамтын ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүргийг Засгийн газрын 2013 оны 97 дугаар тогтоолоор байгуулагдсан Хүн амын асуудлаарх үндэсний хороо хариуцна.

7.2. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцан зохион байгуулна.

7.3. Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж, удирдан зохицуулах ажлыг бүх шатны Засаг дарга хариуцан зохион байгуулна.

7.4. Зорилтот өрх бүрт нийгмийн үйлчилгээг цогцоор хүргэх, хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг төрийн холбогдох байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл бүхий сум, хорооны Хамтарсан баг хариуцна. Хамтарсан багийг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна.

Найм. Хөтөлбөрийн хугацаа

8.1. Хөтөлбөрийг 2016-2020 онд хэрэгжүүлнэ.

Ес. Хөтөлбөрийн санхүүжилт

9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

9.1.1. улс, орон нутгийн төсөв;

9.1.2. Засаг даргын нөөц хөрөнгө;

9.1.3. орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө;

9.1.4. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгө;

9.1.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;

9.1.6. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөрөнгө;

9.1.7. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив;

9.1.8. олон улсын байгууллагын зээл, тусламж, төсөл;

9.1.9. бусад эх үүсвэр.

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

10.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал болон хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор хүргүүлнэ.

10.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бөгөөд хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

Арван нэг. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

11.1. Хөтөлбөр хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

11.1.1. өрхийн ажилгүй байгаа хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэж, ажлын байртай болсон байна.

11.1.2. нийгмийн хамгааллын үйлчилгээ, дэмжлэг туслалцаа зорилтот бүлгийн иргэдэд хүрсэн байна.

11.1.3. өрхийн гишүүдийн боловсролын зохих түвшний сургалтад хамрагдалтын түвшин өссөн байна.

11.1.4. өрхийн гишүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдалтын түвшин нэмэгдсэн байна.

11.1.5. өрхийн гишүүдийн сөрөг зан үйл, дадал арилж, гэр бүлийн харилцаа эерэг, таатай болсон байна.

11.1.6. өрхийн гишүүдийн нийгмийн идэвх, санаачилга нэмэгдэж, олон нийтийн шинжтэй арга хэмжээнд оролцох оролцоо сайжирсан байна.

11.1.7. өрхийн хөгжлийн талаарх цахим мэдээллийн сантай болж, бусад салбар үйл ажиллагаандаа ашигладаг болсон байна.

11.1.8. хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн амьжиргааны түвшин суурь үеийн түвшингээс өсч, өрхийн хөгжлийн түвшин ахисан байна.

11.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр тооцно:

| Хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлт |
|---------------------|--|
| 1 | 11.1.1-д заасан үр дүнгийн хүрээнд а) Өрхийн хөдөлмөрийн насны ажил эрхлэхгүй байгаа хүн амын 50-иас доошгүй хувь нь байнгын ажлын байртай болсон байна. б) Өрхийн хөдөлмөрийн насны ажил эрхлэхгүй байгаа хүн ам хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд бүрэн хамрагдаж, мэргэжил, ур чадвараа ахиулсан, эсхүл мэргэжил эзэмшсэн байна. |
| 2 | 11.1.2-г заасан үр дүнгийн хүрээнд а) Өрхийн гишүүд нийгмийн даатгалд бүрэн хамрагдсан байна. б) Өрхийн гишүүд иргэний бичиг баримтын зөрчлөө бүрэн арилгасан байна. в) Нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, болзлыг хангасан иргэд шаардлагатай үйлчилгээндээ бүрэн хамрагдсан байна. |

| | | |
|---|------------------------------------|--|
| 3 | 11.1.3-т заасан үр дүнгийн хүрээнд | <p>а) Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшин суурь үеийнхээс 50 хувиар нэмэгдсэн байна.</p> <p>б) Суурь боловсрол эзэмших насны хүүхдүүд сургуульд бүрэн хамрагдана.</p> <p>в) Сургууль завсардсан хүүхдүүд боловсрол нөхөн олгох сургалтад бүрэн хамрагдсан байна.</p> |
| 4 | 11.1.4-т заасан үр дүнгийн хүрээнд | <p>а) Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын түвшин суурь үеийнхээс 50 хувиар өссөн байна.</p> <p>б) Өрхийн 5 хүртэлх насны хүүхдүүд өсөлт, хөгжлийн хяналт, вакцинжуулалтад бүрэн хамрагдана.</p> <p>в) Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хяналт, үйлчилгээнд хамрагдалт 100 хувьд хүрнэ.</p> |
| 5 | 11.1.5-д заасан үр дүнгийн хүрээнд | <p>а) Архидан согтуурах, мансуурах, бусдыг хүчирхийлэх, тэнэх зэрэг сөрөг зан үйлтэй өрхийн гишүүдийн тоо 60-аас доошгүй хувиар буурна.</p> <p>б) Хүүхдийн хүмүүжил, халамж, асаргаанд хангалттай цаг зарцуулдаг эцэг, эхчүүдийн хувийн жин суурь үеийн түвшнээс 50 хувиар нэмэгдэнэ.</p> <p>в) Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан орчинд амьдардаг өрхийн хувийн жин суурь үеийн түвшнээс 30 хувиар өснө.</p> |
| 6 | 11.1.6-д заасан үр дүнгийн хүрээнд | <p>а) Сум, хорооноос зохион байгуулж байгаа олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд хөтөлбөрт хамрагдсан өрхийн оролцоо суурь үеийн түвшнээс 50 хувиас доошгүй хувиар нэмэгдэнэ.</p> <p>б) Өрхийн хөгжлийн түвшингээ ахиулсан өрхүүдийн ололт, амжилт, туршлага, сургамжийг сурталчлах ажил тогтмолжсон байна.</p> |
| 7 | 11.1.7-д заасан үр дүнгийн хүрээнд | <p>а) Хөтөлбөрт хамрагдсан өрхийн талаарх цахим мэдээллийн санг хөтөлбөрийн болоод өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашигладаг болсон байна.</p> |
| 8 | 11.1.8-д заасан үр дүнгийн хүрээнд | <p>а) Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн 50-иас доошгүй хувийнх нь өрхийн хөгжлийн түвшин ахисан байна.</p> <p>б) Өрхийн хөгжлийн түвшин ахисан өрхүүдийн 30-аас дээш хувийнх нь амьжиргааны түвшин ядуурлын шугамаас дээш гарсан байна.</p> |